



АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХҮРЛЫН 2020 ОНЫ СОНГУУЛЫД ОРОЛЦОХ
ХЭНГИЙ АЙМГИЙН ӨМНӨДЭЛГЭР СУМЫН МОНГОЛ АРДЫН НАМЫН
ХОРООНЫ МЭРИЙН ХӨТӨЛБӨР

УРИА: ХҮЧ НЭМБЕ



НЭГ. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО

1.1.Орлоготой иргэн

- 1.1.1.1.Гараны бизнес эрхлэгчдэд зориулсан орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлнэ.
- 1.1.1.2.Орлого багатай өрхийн эхлэл эрхлэгчид насанд хүрсэн гишүүдийг бүртгэлжүүлж, мөргөшлн эзэмшүүлэх, ур чадварыг нь ахиулах сурталтат хамруулж, хөдөлмөр эрхлүүлэх боломжийг бүрдүүлнэ.
- 1.1.1.3.Хуримтлалын аяныг сумын хэмжээнд жил бүр өрнүүлнэ.
- 1.1.1.4.Омнөдэлгэр суманд хийгдсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг бодлогоор дэмжиж, тэгш гаранаас бизнес эрхлэх нөхцлийг бий болгоно.
- 1.1.1.5.Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг бизнес инкубацийн үйлчилгээгээр бойжуулж, томруулах бодлогыг үргэлжлүүлж, хамгийн бага түрээс төлөх зохицуулалт хийнэ.
- 1.1.1.6.Иргэдийн туршлага, ур чадвартаа түшиглэн хийж байгаа бизнесийг дэмжиж, шаардлагатай техник, тоног төхөөрөмж, төхөөрөмж авах хөнгөлөлттэй зээл олгоно.

1.2.Хуримтлалын нэгдсэн сан ба орон сууцтай өрх

- 1.2.1. Орон сууцны төлөвлөгтөд сургууль, цэцэрлэг, ногоон байгууламж, усан сан, биеийн тамирын талбай бүхий тохилог орчин бүрдүүлэх стандарт хэрэгжүүлнэ.
- 1.2.2. Хүн бүрийг хөдөлмөрийн цахим бүртгэлтэй болгож, нийгмийн даатгал, хамгааллын тогтолцоотой уялдуулж, хөдөлмөр эрхлэлтийн хариуцлагыг нэмэгдүүлнэ.
- 1.2.3. Иргэн бүрд суурь тэтгэвэр олгох, хувийн даатгалын үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлнэ.
- 1.2.4. Өрх бүрийг хуримтлалтай, хүүхэд бүрийг хадгаламжтай болох боломжийг бүрдүүлнэ.

1.3.Эрүүл иргэн

- 1.3.1.1.Сумын эрүүл мэндийн төвийн удирдлага, менежментийг улс төрөөс ангид байлгаж, чадварлаг хүний нөөц хамт олны дэмжлэгт тулгуурлан томилно.
- 1.3.1.2.“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийг сумандаа үргэлжлүүлж, “Хавдрын эсрэг хамтдаа” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.
- 1.3.1.3.Хеликобактеритэй тэмцэх, хянах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж нянгийн шалтгаант хоолоодны архаг үрэвсэл, шарх, хорт хавдрын шинэ тархалтыг таслан зогсооно.
- 1.3.1.4.Иргэдэд эрүүл мэндийн бүх талын боловсролыг ЕБС-д сурацгааж байх үеэс олгож, эрүүл мэндийн “анхны тусламж” үзүүлэх чадавхыг хүн бүрд эзэмшүүлнэ.
- 1.3.1.5.ЭМТөвийн амбулаторийн барилга асуудлыг шийдвэрлэнэ.



1.4. Чанартай боловсрол

- 1.4.1.1. Ерөнхий Боловсролын Сургууль, цэцэрлэгийн багш, ажилтны нийгмийн болон хөдөлмөрийн үнэлэмжийг үнэлэх аймгийн бодлогыг дэмжин ажиглана.
- 1.4.1.2. "Удмын хоёд" хөтөлбөрийг үргэлжлүүлж, хүүхдэд шинэ тэжээл, амни дэмээр байлаг хоолоор үйлчилнэ.
- 1.4.1.3. Өмнөдэлгэр сумын ЕБС-ийн барилгыг ашиглалтад оруулна
- 1.4.1.4. Суратчдын сонирхол, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, сонгон, секц, дуугүйлэлтийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.

1.5. Тогтвортой-амар, амгалан гэр бүл

- 1.5.1.1. Орхийн амьжиргааны тувшинг тогтоох аргачлалд тулгуурлан хүнсний талон зэрэг нийгмийн халамжийн үйлчилгээг зөвхөн зорилгот бүлэгт чиглүүлнэ.
- 1.5.1.2. Орлого багатай өрхийн нийгмийн хамгаалал, амьжиргааг дээшлүүлэх олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг нэвтрүүлнэ.
- 1.5.1.3. Угийн бичгээ хөтлөх, цус ойртолтоос урьдчилан сэргийлэх, удмын сангаа хамгаалах ажлыг зохион байгуулна.
- 1.5.1.4. Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах ажлыг үе шаттай зохион байгуулна.
- 1.5.1.5. Иргэдэд зориулсан хувь хүний хөгжлийн сургалт, лекцыг зохион байгуулна

1.6. Хүүхэд хамгаалал, хөгжил

- 1.6.1.1. Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, нийгмийн төлөвшилтийг дэмжихэд эцэг, эхчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.
- 1.6.1.2. Хүүхдийн тоглоомын талбай, орчны стандартыг мөрдүүлж, хүүхдэд аюулгүй орчин бүрдүүлж, хяналтыг сайжруулна.
- 1.6.1.3. Хүүхэд хамгаалал тур хамгаалах байртай болно.

1.7. Хан Хэнтийн Залуучуудын хөгжил

- 1.7.1.1. Залуучууд, залуу гэр бүлийг малжуулах төсөлд хамруулж дэмжлэг үзүүлнэ.
- 1.7.1.2. Гэр бүл, хүүхэд, оюутан, залуучууд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх орчин бий болгоход зориулсан төвийг шинээр байгуулна.
- 1.7.1.3. Хүүхэд, оюутан, залуучууд, өсвөр үеийнхнийг гадны сөрөг нөлөө, бусдын дарамт, гэмт хэрэгт өртөх, мансууруулах болон сэтгэлд нөлөөлөх бодис хэрэглэхээс сэргийлэх, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.8. Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэдэд дэмжих

- 1.8.1.1. Тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэдийн эрх, оролцоог хангаж, нөхөн үзэх эмчилгээ, сувилгаа болон хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.



1.9. Ахмадуудад үзүүлэх үйлчилгээ

- 1.9.1.1. Ахмадын хөгжлийн аймаг дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 1.9.1.2. Ахмад настан чөлөөт цагаа үр дүнтэй өнгөрүүлэх, мэдээлэл авах, хөгжих боломжийг бүрдүүлэх хөгжлийн төслийн үйлдвэрлэлийг тогтмол болгох.

1.10. Үндэсний бахархал, өв соёл, спорт

- 1.10.1.1. Огнолт, соёл иргэний, үнэт зүйлийг танилцуулсан өв, соёл, урлаг, аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 1.10.1.2. Түүх, соёлын өвийг бүтээж байгаа хууль бус үйл ажиллагаатай хатуу тэмцэж, хариуцлагыг чангатгаж, биет болон биет бус өвийг хамгаална.

2. ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

2.1. Эдийн засгийн төрөлжилт

2.1.1. ХАА-н чиглэл

- 2.1.1.1. Тог нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр бүрэн хангах бодлогыг орон нутгийн түвшинд тууштай хэрэгжүүлнэ.
- 2.1.1.2. Мал, амьтны гаралтай арьс, шир, үс, ноос, ноолуурыг бүрэн боловсруулж, оёмол, сүлжмэл бэлдэн бүтээгдэхүүний экспортын хэмжээг нэмэгдүүлэхэд сумын иргэд, малчдыг татан оролцуулна.
- 2.1.1.3. “Монгол мал-2” хөтөлбөрийг хэрэгжүүлж, малыг эрүүлжүүлэх, чанар, ашиг шимийг сайжруулах ажлыг эрчимжүүлж, малын тоог чанарт шилжүүлж ашиг шим, хүртээмжийг сайжруулах, малын генийн санг хамгаална.
- 2.1.1.4. Төмс, байцаа, манжин, лууван, сонгино, сармис зэрэг хүнсний ногоогоор сумын хэрэгцээг бүрэн хангана.
- 2.1.1.5. Хүлэмж, аглуулахын аж ахуйг хөгжүүлэх замаар хүнсний ногооны дотоодын хэрэгцээг жилийн турш тогтвортой хангана.
- 2.1.1.6. Аялал жуулчлалын үйлчилгээний чанар, эрүүл ахуйн шаардлагыг сайжруулж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 2.1.1.7. Жижиг дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.
- 2.1.1.8. Түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, нутгийн брэнд бүтээгдэхүүний зах, дэлгүүр болно.
- 2.1.1.9. Усалгаатай төмс хүнсний ногоо тариалалтын бодлогоор дэмжинэ

2.2. Үндэсний дэд бүтцийн сүлжээ

- 2.2.1.1. Баянбулаг хороололд 04-ийн цахилгааны шугам хийнэ.
- 2.2.1.2. Жаргалтхаан, Өмнөдэлтэр чиглэлийн замын ажлыг эхлүүлнэ.



ГУРАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

3.1. Цахим Хэлтий-шуурхай төрийн үйлчилгээ

3.1.1. Хүнд сурталгүй мөрийн үйлчилгээг өндөр түвшинд гүйцэтгэх, төрийн байгуулалтуудад үйлчилгээг сайжруулж, мөрийн албан хаагчдыг чадавхжуулж, төсвийн зардлыг хэмнэнэ.

3.1.2. Төрийн байгуулалтын эд хөрөнгийн ангилалт, бүртгэл, хамгаалалтын байдалд үнэгэлт дүгнэлт өгөх, холбогдох арга хэмжээ, хариуцлага тооцож ажиглана.

3.1.3. Орон нутгийн хөгжлийн сан, бусад нийтийн эрх ашигт үйлчилгээт сэлтийн үйл ажиллагааг иргэд, хувийн хэвшлийн үйл ажиллагааг дэмжихэд чиглүүлэн, олон нийтэд нээлттэй, хяналттай тогтолцоонд бүрэн шилжүүлнэ.

3.2. Мэргэшсэн, ёс зүйтэй төрийн алба

3.2.1. Төрийн албан хаагч ажил үүргээ гүйцэтгэхдээ танил талдаа давуу тал олгохгүй байх, явцуу сонирхол, намын харьяаллаар иргэдэд ялгавартай хандахгүй байх зарчмыг бүрэн хэвшүүлнэ.

3.2.2. Төрийн албан хаагчдыг тасралтгүй сургаж хөгжүүлэх цахим сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын мэдлэг чадвар, хандлагыг эрс шинэчилнэ.

3.2.3. Төрийн жинхэнэ албан хаагч сонгуулийн үр дүнтээс үл хамааран чадахуйн богино шатлан дэвших зарчмын дагуу төрийн албанд тогтвортой ажиллах нөхцөлийг бодитгоор хэрэгжүүлнэ.

3.3. Ардчилсан, хүний эрхийг дээдлэх

3.3.1. Сумын төвийн гудамж талбайг камержуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг эрчимжүүлнэ.

3.3.2. Зам тээврийн ослоос урьдчилан сэргийлж, орон нутгийн авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хяналтыг сайжруулна.

3.3.3. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж буй эмэгтэйчүүд, хүүхэд, ахмад настан, тусгай хэрэгцээ (хөгжлийн бэрхшээл)-тэй иргэдийг хамгаалах төрөлжсөн түр хамгаалах байр, мэдээлэл, зөвлөгөө өгөх төвийг байгуулна.

3.3.4. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, Хэрэглэгч хаан дэд хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлнэ.

ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

4.1. Баталгаат ундны ус

4.1.1. Цэнтгэл усны нөөц, гол мөрний урсал бүрэлдэх эхийг аймаг, улсын тусгай хамгаалалтад авах саналыг гаргана.

4.1.2. Хиймэл нуур, цөөрөм, хөв байгуулах, гадаргын ус ашиглах санаачлагыг дэмжинэ.

4.1.3. Баянбулаг хороололд худгийн байшин ашиглалтанд оруулна.

4.1.4. Хангал хороололд худгийн байшин ашиглалтанд оруулна.

4.1.5. Наран багийн худагруу өндөр хүчдлийн шугам татна.



4.2. Хүрээлэн буй орчин, уур амьсгалын өөрчлөлт

- 4.2.1. Тусгай хамгаалалттай газар, хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээг нэмэгдүүлнэ.
- 4.2.2. Сум суурин газрын ногоон байгууламжийн эзлэх талбайн хэмжээг 15 хувьд хүргэнэ.
- 4.2.3. Сургууль, дүүрэг, 200 м хүртэлх заагийг ногоон байгууламжтай болгох ажлыг эхлүүлнэ.
- 4.2.4. Байгалийн усжуулах, хөдөлжүүлэх ажлыг үргэлжлүүлэн малын бэлтгэлийн нөөцийг нэмэгдүүлнэ.
- 4.2.5. Байгалийн усжуулах, хөдөлжүүлэх ажлыг үргэлжлүүлэн малын бэлтгэлийн нөөцийг нэмэгдүүлнэ.

4.2.6. Сумын төвийн гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ

ТАВ. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

5.1. Бүс, орон нутгийн хөгжил

5.1.1. Хөдөө орон нутагт бизнес эрхлэгчдийг төрийн бодлогоор дэмжин ажлын байрыг нэмэгдүүлнэ.

5.1.2. Суурин газруудад байгаа хуучирч муудсан, эзэн эзэмшил, цаашид хэрхэх нь тодорхойгүй, иргэд олон нийтийн аюулгүй амгалан байдалд сөргөөр нөлөөлөхүйц барилга байгууламжийн эздийг тогтоон нэг мөр цэгцлэх, газрыг чөлөөлүүлэх, буулгах, шинээр бүтээн босгож эдийн засаг, нийгмийн эргэлтэд оруулна.

5.1.3. Тендер хөрөнгө оруулалтын төсөв, шалгаруулалтыг ил тод нээлттэй зохион байгуулах, асуудал маргаангүй шийдвэрлэх бүх боломжийг бий болгох, хариуцлагажуулна.

5.2. Хот хөдөөгийн тэнцвэртэй хөгжил

5.2.1. Хурх тосгоныг шинэн кабелид холбоно.

5.2.2. ЕБСургууль бага оврын автобустай болгоно.



4297
9074082